



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/16

Зуунмод сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны А/71 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”, 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийсэн “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт нийцлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг баталгаажуулсугай.

2. Нийцлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Г.Ариун-Уянга нарт үүрэг болгосугай.

3. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээ авч, илэрсэн алдаа зөрчлийг арилган, хэрэгжилтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Төв чандмань ДЭХГ ОНӨААТҮГ-ын Захирал Д.Баярбат, БЗОСК ОНӨААТҮГ-ын Захирал Ц.Дашдэмбэрэл нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Г.Ариун-Уянга нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ТӨАГ-2025/21-18-ШТА-НА

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Жаргалсайхан

Утас: 70273465 Цахим хаяг: jargalsaikhanl@audit.gov.mn

Аудитор Г.Ариун-Уянга

Утас: 70272582 Цахим хаяг: ariun-uyangag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Хүснэгтийн товъёг.....	1
Товчилсон үгийн тайлбар.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	3
А.Төрийн хэмнэлтийн тухай хууль бүрэн хэрэгжихгүй байна.....	5
<i>А.1. Тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцастай холбоотой зөрчил давтан гарсаар байна.....</i>	<i>5</i>
<i>А.2. Хуулийн хэмнэлтийн бусад арга хэмжээ гэсэн 15 дугаар зүйлтэй холбоотой зөрчил бүрэн арилахгүй байна.....</i>	<i>7</i>
Б. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хөрөнгө оруулалттай холбоотой 13 дугаар зүйлийн 13.3.3-д заасан хязгаарлалт бүрэн хэрэгжихгүй байна.....	9
<i>Б.1. Аймаг, сумдын орон нутгийн хөрөнгө оруулалтаар зураг төсөв нь батлагдаагүй зарим ажлуудыг тусган хэрэгжүүлж байна.....</i>	<i>9</i>
<i>Б.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааг бүрэн цахим системээр явуулж байна.....</i>	<i>11</i>
В. Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал зардал хэмнэгдсэн байна.....	12
<i>В.1. Төрийн аудитын байгууллага хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.....</i>	<i>12</i>
<i>В.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал зардал хэмнэгдсэн байна.....</i>	<i>12</i>
<i>В.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил буурахгүй байна.....</i>	<i>14</i>
ДҮГНЭЛТ:.....	16
ЗӨВЛӨМЖ:.....	17

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4-8 дугаар зүйлтэй холбоотой зөрчлийн нэгтгэл.....	5
Хүснэгт 2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчил.....	12
Хүснэгт 3. Төв аймгийн 2023 оны нийт зарлагын эдийн засгийн ангилал.....	13
Хүснэгт 4. Төв аймгийн 2024 оны нийт зарлагын эдийн засгийн ангилал.....	13
Хүснэгт 5. 2022-2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчил.....	15

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
УИХ	Улсын Их Хурал
БЗОСК	Барилга захиалагч, орон сууцны корпораци
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТББ	Төрийн бус байгууллага
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**Аудитын зорилт****Аудитын хамарсан хүрээ****Аудитын хязгаарлалт****Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт****Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол болон Монгол улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108 дугаар тушаал, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасны дагуу аудит хийлээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийсэн. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан уу?
- Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан уу?
- Засгийн газар болон төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан уу?

Аудитыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон улсын төсвөөс санхүүждэг байгууллагуудын 2022, 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай уялдуулан улс, орон нутгийн төсвийн байгууллагууд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2024 оны үйл ажиллагааг түүвэрт хамруулж, холбогдох баримт материалын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Байхгүй.

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- МУЕА-ын баталсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн аудитын төлөвлөгөөнд тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд,
- Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоол,
- Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоол,
- Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоол

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Г.Ариун-Уянга нар гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр ҮАГ-т хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл

Байхгүй.

А.Төрийн хэмнэлтийн тухай хууль бүрэн хэрэгжихгүй байна.

А.1. Тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцастай холбоотой зөрчил давтан гарсаар байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/59 дүгээр тушаалаар Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, А/89 дүгээр тушаалаар Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэлийг хэрэгжүүлэх заавар тус тус батлагдсан.

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн болон шууд захирагчийн 2023, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит, эдгээр онуудад хийж гүйцэтгэсэн гүйцэтгэл, нийцлийн аудитад Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэлийг хэрэгжүүлэх зааврыг мөрдөн ажилласан. Энэхүү нийцлийн аудитыг өмнөх онуудад хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн асуудал, зөрчлийн нэгтгэлийг ашиглан 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудиттай уялдуулан гүйцэтгэлээ.

Хүснэгт 1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4-10 дугаар зүйлтэй холбоотой зөрчлийн нэгтгэл

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчигдсэн хязгаарлалт	Он	Тоо	Дүн /мян.төг
Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим	2023	0	0
	2024	22	311,031.4
Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхтэй холбоотой хязгаарлалт	2023	1	28,340.8
	2024	0	0
Тээврийн хэрэгслийн хязгаарлалт	2023	7	0
	2024	2	0
Дүрэмт хувцасны хязгаарлалт	2023	2	1,440.0
	2024	3	7,071.2
Цалин хөлстэй холбоотой хязгаарлалт	2023	0	0
	2024	2	4,297,465.9
Нийт дүн	2023	10	29,780.8
	2024	29	4,615,568.5

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх” гэж заасан. Төсвийн шууд захирагчдын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй бол 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчимтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар Улсын заан Д.Хүдэрбулгад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааны зардалд 2,639.0 мянган төгрөг, төрийн албаны өдрийн үйл ажиллагааны зардалд 1,256.2 мянган төгрөгөөр гарын бэлэг болон хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан, ахмадын холбоонд гольфийн иж бүрдэл болох бөмбөг, цохиур авахад нийт 600.0 мянган төгрөг зарцуулсан,
- Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар төсвөөс шинэ жил тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд 1,250.0 мянган төгрөг зарцуулсан,
- Эрдэнэсант сумын Засаг даргын Тамгын газар андгай өргөх ёслолын

ажиллагаанд бэлгийн багц 1,250.0 мянган төгрөг, ахмадын хорооны бэлэг дурсгалд 400.0 мянган төгрөг зарцуулсан,

- Аргалант сумын Эрүүл мэндийн төв хүүхдүүдийн бэлэг авахад төсвөөс 318.2 мянган төгрөг зарцуулсан,
- Аймгийн Эрүүл мэндийн газар Ахмадын хүлээн авалтын материалын үнэ, баярын арга хэмжээний зардалд зориулж 522.5 мянган төгрөг зарцуулсан,
- Аймгийн Нэгдсэн эмнэлэг ахмадын баяр, хүүхдүүдийн баярын арга хэмжээний зардалд 3,700.0 мянган төгрөг зарцуулсан,
- ТӨВ АЗЗА ТӨХК Монголын авто замчдын холбоо ТББ-ын үйлчилгээ, гишүүний татварт 4,750.0 мянган төгрөг шилжүүлсэн зэрэг 16,685.9 мянган төгрөгийн 9 зөрчил илэрснээс 7,650.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 4,495.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага бичигдэж, 4,540.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.
- Аймгийн ЗДТГ төсвөөс ганданд ном уншуулахад 3,700.0 мянган төгрөг, шинэ жилийн арга хэмжээнд 59,965.0 мянган төгрөг, байгууллагын шинэ жил тэмдэглэхэд 13,050.0 мянган төгрөг, хоолны зардалд 145,830.5 мянган төгрөг нийт 222,545.5 мянган төгрөгийг зарцуулсан.
- Гадаад томилолтын зардал батлагдаагүй байхад Алтанбулаг, Баян, Баянчандмань, Заамар, Зуунмод, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Угтаал сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Аймгийн ИТХ-ын зохион байгуулалт, олон нийттэй харилцах хэлтсийн дарга, ажлын албаны мэргэжилтэн, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга нар Турк улс руу туршилага солилцох хөтөлбөрт хамрагдан 71,800.0 мянган төгрөг шилжүүлэн зарцуулсан зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

Нийт 311,031.4 мянган төгрөгийн 22 зөрчил илэрснээс 7,650.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 298,840.2 мянган төгрөгийн 16 албан шаардлага бичигдэж, 4,540.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын нэг орлогчийг чөлөөлж, 2022 оны Б/25 дугаар захирамжаар Засаг даргын зөвлөхийн орон тоонд томилон ажиллуулсан нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д “Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн тул аймгийн ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөхөөр ажилласан хугацааны цалин 28,340.8 мянган төгрөгийн акт тавьсан.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүү, нийцлийн аудитаар Аргалант, Баянцогт, Заамар, Өндөрширээт, Зуунмод сумдын ЗДТГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Төв аймаг дахь ШТН ТӨААТҮГ, Төв аймаг дахь Шүүхийн тамгын газар зэрэг 7 байгууллагын албан ажлын автомашинуудад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэснийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлж, 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Онцгой байдлын газар, БЗОСК ОНӨААТҮГ-ын 2 автомашин цэнхэр өнгийн улсын дугаар тавиагүй зөрчилд зөвлөмж өгч тус тус зөрчлийг арилгуулсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан дүрэмт хувцасны хязгаарлалттай холбоотой зөрчил 2023 онд 2, 2024 онд 3 гарсан. Аргалант сумын ЗДТГ төсвийн хөрөнгөөр 1,080.0 мянган төгрөгөөр 18 ширхэг биеийн тамирын хослол, Зуунмод сумын ЗДТГ төсвөөс 360.0 мянган төгрөгөөр дүрэмт хувцас бэлтгэсэн зөрчил 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрч төлбөрийн акт тавигдсанаас Аргалант сумын ЗДТГ-ын акт хэрэгжиж, Зуунмод сумын ЗДТГ-ын акт барагдаагүй байна.

Тайлант 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар Аргалант сумын ЗДТГ тушаал шийдвэргүйгээр ажилчдын гутал 516.0 мянган төгрөгөөр худалдан авсан, Эрдэнэсант сумын ЗДТГ ажилчдын хувцас авахад 5,000.0 мянган төгрөг зарцуулсан, Заамар сумын Соёлын төв 4 ширхэг бомбер, 5 ширхэг хослол, 5 ширхэг поло цамц нийт 1,555.2 мянган төгрөгийн хувцас төсвийн хөрөнгөөр авсан зөрчил илэрч 7,071.2 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт бичсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, **орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно**” гэж заасан. Түүвэрт хамрагдсан Төв чандмань ДЭХГ, БЗОСК ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал болон бусад албан хаагчдын цалин хөлсний нийтлэг жишгийг ИТХ-аар тогтоогоогүй байна. Тухайлбал:

- Төв чандмань ДЭХГ ОНӨААТҮГ-ын захирлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилж цалин хөлсийг тогтоосон, захирал нь жил бүр тухайн онд мөрдөх орон тоо цалингийн сан батлах тушаал гаргаж ирсэн байна.
- БЗОСК ОНӨААТҮГ-ын 2023, 2024 онуудад ТУЗ-ын тогтоолоор захирал, албан хаагчдын цалин хөлс, цалингийн санг баталсан байна.

Энэ нь хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасныг зөрчсөн байх тул зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

А.2. Хуулийн хэмнэлтийн бусад арга хэмжээ гэсэн 15 дугаар зүйлтэй холбоотой зөрчил бүрэн арилахгүй байна.

Төсвийн шууд захирагчдын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэмнэлтийн бусад арга хэмжээ гэсэн 15 дугаар зүйлтэй холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Төрийн улс төрийн албан тушаалтнуудад орон нутгийн нэмэгдэл олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэснийг зөрчсөн. Тухайлбал, Архуст, Алтанбулаг, Аргалант Баяндэлгэр, Баянхангай, Баянцагаан, Баянцогт, Баянчандмань, Баян-Өнжүүл, Борнуур, Бүрэн, Дэлгэрхаан, Жаргалант, Заамар, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сүмбэр, Угтаалцайдам, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант, Зуунмод зэрэг 22 суманд Засаг дарга, Засаг даргын орлогч, багийн дарга, ИТХ-ын дарга зэрэг улс төрийн албан тушаалтнуудад орон нутгийн нэмэгдэл олгосон зөрчилд нийт 313,981.7 мянган төгрөгийн акт тавигдсанаас 290,360.9 мянган төгрөг төлөгдөж актын хэрэгжилт 93.0 хувьтай байна.
- Сэргээлэн сумын ЗДТГ нь 100 жилийн ойн угтсан үйл ажиллагаанд 330,931.4 мянган төгрөгийг зарцуулахдаа баримтат кино, дууны клип зэрэгт зардал гаргасан нь хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4-д “... шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэснийг зөрчсөн.
- Зуунмод сумын ЗДТГ, Баянцагаан сумын ИТХ, хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэснийг зөрчин 12,380.6 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл авч тараасан зөрчилд албан шаардлага өгч зөрчлийг арилгуулсан.
- Борнуур сумын соёлын төв сургалт явуулах эрх, тусгай зөвшөөрөлгүй,

хөтөлбөргүй, сургалтын зардалд 1,579.5 мянган төгрөг зарцуулсан нь хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтыг зөрчсөн байх тул албан шаардлага өгч зөрчлийг арилгуулсан.

- Төв аймаг дахь Шүүхийн тамгын газар, Аргалант сумын ЗДТГ цалингийн зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлэлгүй ахмадын санд шилжүүлсэн, улсын байцаагчийн тавьсан актын алдангийг төсвөөс төлсөн, ЗДТГ-ын даргад 2 удаа мөнгөн урамшуулал олгосон зэрэг зөрчил гаргасан нь хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэснийг зөрчсөн тул 9,182.7 мянган төгрөгийн 3 акт, 335.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч бүрэн барагдуулсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэмнэлтийн бусад арга хэмжээ гэсэн 15 дугаар зүйлтэй холбоотой нийт 687,143.0 мянган төгрөгийн 57 зөрчил илэрсэнд 324,923.9 мянган төгрөгийн 52 төлбөрийн акт тавигдаж, 362.2 сая төгрөгийн 5 албан шаардлага бичиж хэрэгжилтийг хангуулсан.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Баяндэлгэр, Дэлгэрхаан сумын ИТХ нь хурлын төлөөлөгчдөд урамшуулал олгосон, аймгийн ЗДТГ, Баяндэлгэр сумын ЗДТГ, Мөнгөнморьт сумын ЗДТГ Засаг даргын орлогчид ажлаас чөлөөлөгдсөний 6 сарын тэтгэмж олгосон, Баяндэлгэр сумын хүүхдийн цэцэрлэг, аймгийн Бүжинхэн хүүхдийн цэцэрлэг, Бүрэн сумын хүүхдийн цэцэрлэг, аймгийн Онцгой байдлын газар нягтлан бодогчид балансын шагнал олгосон зэрэг нь хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэснийг зөрчсөн тул 6,329.1 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 39,695.6 мянган төгрөгийн 5 албан шаардлага бичиж 1 зөвлөмж өгсөн.
- Аргалант, Сэргэлэн сумдын ЗДТГ, аймгийн Худалдан авах ажиллагааны газар байгууллагын танилцуулга, кино контент, телевизийн нэвтрүүлэг зэрэгт 13,970 мянган төгрөг зарцуулсан нь хуулийн 15.1.4-д “...салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэснийг зөрчсөн тул 10,094.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3,876.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.
- Баян-Өнжүүл, Мөнгөнморьт сумдын ЗДТГ, аймгийн ГХБХБГ төсвийн хөрөнгөөр 15.8 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэж, олгосон зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтыг зөрчсөн. 12,820 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3,042.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэснийг зөрчин Аргалант, Эрдэнэсант сумдын ЗДТГ, Баянжаргалан, Сэргэлэн сумдын соёлын төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагууд 12,561.5 мянган төгрөгийн хүнсний материал, шатахуун талон, шатах тослох материал нөөцөлсөн. Эдгээр зөрчилд 11,785.0 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 776.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.
- Аргалант сумын ЗДТГ тушаал шийдвэргүй 790.0 мянган төгрөгийн гарын бэлэг, 70.5 мянган төгрөгийн халуун вино, нийт 860.5 мянган төгрөг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн нь хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д “байгууллагын төсвөөр

согтууруулах ундаа худалдан авах” гэж заасныг зөрчсөн тул төлбөрийн акт тавьсан.

- *Аргалант, Баян, Баянхангай сумдын ЗДТГ хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэснийг зөрчиж 5.7 сая төгрөгийг спортын уралдаан тэмцээнд зарцуулсан. Зөрчлийг таслан зогсоох 4.9 сая төгрөгийн 2 албан шаардлага, 0.8 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.*
- *Баяндэлгэр, Дэлгэрхаан Жаргалант Баянцогт сумд болон Зуунмод сумын Дэгдээхэй хүүхдийн цэцэрлэг, Цээл, Баянчандмань, Архуст, Баянчандмань, Жаргалант, Цээл сумдын эрүүл мэндийн төв зэрэг 13 байгууллага цалин хөлсний нэмэгдлийг буруу тооцсон, сахилгын шийтгэлтэй албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгосон, цалин илүү тооцож олгосон зэрэг зөрчил гаргасан нь хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэснийг зөрчсөн. Нийт 34,156.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 30,443.6 мянган төгрөгийн 8 төлбөрийн акт, 3,713.1 мянган төгрөгийн 5 албан шаардлага бичсэн.*
- *Аймгийн Онцгой байдлын газар сургалт семинарын хоол, буудлын зардалд 16,000.0 мянган төгрөг зарцуулсан нь хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх” гэснийг зөрчсөн тул зөвлөмж өгсөн.*

Төсвийн байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 15 дугаар зүйлтэй холбоотой нийт 145,800.4 мянган төгрөгийн 39 зөрчил илэрсэнд 37,633.2 мянган төгрөгийн 12 төлбөрийн акт тавигдаж, 83,001.1 мянган төгрөгийн 20 албан шаардлага бичигдэж, 25,166.1 мянган төгрөгийн 7 зөвлөмж өгсөн.

Өмнөх 2023 онтой харьцуулахад хуулийн 15 дугаар зүйлтэй холбоотой зөрчил 541,324.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Б. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хөрөнгө оруулалттай холбоотой 13 дугаар зүйлийн 13.3.3-д заасан хязгаарлалт бүрэн хэрэгжихгүй байна.

Б.1. Аймаг, сумдын орон нутгийн хөрөнгө оруулалтаар зураг төсөв нь батлагдаагүй зарим ажлуудыг тусган хэрэгжүүлж байна.

Төрийн аудитын байгууллагаас жил бүр улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэл, нийцлийн аудит хийгддэг. Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан зарим төсөл, арга хэмжээнүүдийн хувьд дараах зөрчил илэрсэн:

- *Баянцагаан сумын гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбох ажлын зураг төсөв нь магадлалын дүгнэлтээр батлагдаагүй.*
- *Заамар сумын ЭМТ-ийн өргөтгөлийн ажлын зураг төсөв хийгдэж, магадлалын дүгнэлтээр баталгаажаагүй байхад төсөвт тусган баталсан.*
- *Алтанбулаг сумын ЭМТ-ийн барилгын өргөтгөлийн зураг, төсөв нь хийгдээгүй байхад төсөвт тусгаж баталсан, худалдан авах ажиллагаа явагдаж, гэрээ байгуулагдсаны дараа магадлалын дүгнэлт гарсан.*

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29.2.2 болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д заасныг зөрчсөн тул 1,807,108.3 мянган төгрөгийн дүнтэй зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгсөн.

Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- *Баянчандмань сум зураг, төсөв шаардлагатай 223,613.1 мянган төгрөгийн 6 ажил, мөн тухайн оны төсөвт батлагдаагүй 105,800.0 мянган төгрөгийн 6 ажил, нийт 329,413.1 мянган төгрөгийн 12 ажил зураг, төсөвгүй хэрэгжүүлсэн байна*
- *Баянцогт сум нь 2024 онд орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдаагүй 54,000.0 мянган төгрөгийн 3 ажилд урьдчилгаа санхүүжилтэд 70 хувийг олгосон. Эдгээр зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.*
- *Сэргэлэн сумын ИТХ-аар батлаагүй байхад наадмын талбайн тохижилтын ажилд 22,060.2 мянган төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж, санхүүжилт олгосон зөрчилд албан шаардлага өгсөн.*
- *Баян сумын ЕБС-ын спорт заалны барилгын ажлыг сумын орон нутгийн төсвөөр 2,099.4 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн. Сумын ИТХ-аар 2024 онд газрын дуудлага худалдаанаас орсон орлогоос үнийн зөрүү тооцуулах төсвийн зардал гэж 328,400.0 мянган төгрөг баталж, ЕБС-ын спорт заал шинээр барих ажлын гэрээ /үнийн өсөлт/ гэсэн нэмэлт гэрээ байгуулан, 328,400.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үнийн зөрүүний тооцооллыг гүйцэтгэгч компани өөрөө гаргасан бөгөөд ямар нэг хөндлөнгийн хяналт, магадлалын дүгнэлт хийгдээгүй байна.*

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 29 дүгээр зүйлийн 29.4-д "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", 29¹.2.2-т "барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д "техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.31-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхгүй" гэж заасныг тус тус зөрчсөн байна. Дээрх зөрчилд хариуцлага тооцох 383,413.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг таслан зогсоох 22,060.2 мянган төгрөгийн нэг албан шаардлага өгч Баян сумын ЕБС-ын спорт заалны барилгын ажилд 328,400.0 мянган төгрөгийн үнийн зөрүү олгосон зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн.

Мөн Монгол Улсын ЗГХЭГ-ын даргын төсвийн багцад батлагдсан сум, багийн хөгжлийг дэмжих, чадавхжуулах хөтөлбөр арга хэмжээнээс 300,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эрхийг Төв аймгийн Засаг даргад 2024 оны 41 дүгээр тушаалаар шилжүүлсэн байна. Тус хөтөлбөрийг Зуунмод сумын 6 багийн төвийн байрны засал, дотор халаалт болон Эрдэнэ сумын Хушинга багийн төвийн байр засварлах 7 багцад хуваан худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлсэн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно", 13.4.4-д "багийн төв, хорооны засаг захиргааны зориулалттай барилга барих, тохижуулах, засварлах, тоног төхөөрөмж худалдан авах" гэж заасныг зөрчсөн байна. Энэ зөрчлийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт нийцлийн аудитын нэгдсэн тайланд тусган холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх саналтай байна.

Б.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааг бүрэн цахим системээр явуулж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалт орон нутагт tender.gov.mn цахим сайт ашиглан хэрэгжиж байна. Захиалагч нь шаардлагатай бараа үйлчилгээний захиалгаа цахим сайтаар дамжуулан өгдөг, аймгийн хэмжээнд нийт хэдэн байгууллага хэчнээн төрлийн, ямар үнийн дүн бүхий захиалга өгсөн нь тус сайт болон аймгийн ХААГ-аас гардаггүй тул дүгнэлт өгөх боломжгүй байна.

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалтын хүрээнд 2023, 2024 онуудад цахим дэлгүүрт байршсан 309 зөөврийн компьютер, 60 ширхэг таван ханатай гэр, нийт 528.1 сая төгрөгөөр худалдан авсан байна.

Хуулийн 14.5-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана” гэж заасан. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд аймаг, сум, төсөвт болон орон нутгийн өмчит өмчит газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийт 74,221.4 сая төгрөгийн 1385 төсөл, арга хэмжээг бүртгэснээс оны эцэст тендер зарлавал зохих 59,733.4 сая төгрөгийн 513 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнээс 54,172.1 сая төгрөгийн 416 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалт зарласан байна.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2024 онд аймаг, сумдын болон орон нутгийн өмчит нийт 41 захиалагч, байгууллагаас улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 109,512.5 сая төгрөгийн 1461 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг цахим системд бүртгэсэн. Үүнд:

- *Захиалагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 2 дугаар тогтоолд зааснаар 20.0 сая буюу түүнээс доош төсөвт өртөгтэй төсөл, хөтөлбөр, арга хэмжээг “шууд худалдан авах” аргаар зохион байгуулах 9,569.6 сая төгрөгийн 841 төсөл, арга хэмжээ,*
- *Төсөвт өртөгийн дээд хязгаараас дээш төсөвт өртөгтэй тендер зарлах 99,942.9 сая төгрөгийн 620 төсөл, арга хэмжээ бүртгэгдсэн*

Тайлант 2024 оны жилийн эцэст 97,652.7 сая төгрөгийн 1296 төсөл, арга хэмжээнд худалдан авалт хийгдсэн байна. Үүнээс шууд худалдан авалт 841 төсөл, арга хэмжээ, тендер зарласан 455 төсөл, арга хэмжээ байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар бүрэн зарлаж ажилласан байна

В. Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал зардал хэмнэгдсэн байна.

В.1. Төрийн аудитын байгууллага хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана” гэж заасан. Аймаг, орон нутагт Төрийн аудитын байгууллага Монгол улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, А/89 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэлийг хэрэгжүүлэх зааврыг баримтлан хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудит гүйцэтгэхдээ дээрх зааврыг баримтлан ажиллаж Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Хүснэгт 2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчил /мян,төг/

Зөрчилд авсан арга хэмжээ	2023 он		2024 он		Өссөн буурсан	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Төлбөрийн акт	55	354,704.7	18	52,354.4	-37	(302,350.3)
Албан шаардлага	5	362,219.1	26	492,969.6	21	130,750.5
Зөвлөмж	10	1,807,108.3	12	4,327,172.7	2	2,520,064.4
Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	0	-	1	328,400.0	1	328,400.0
Нийт	70	2,524,032	57	5,200,897	- 13	2,676,865

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

2023 онд хийсэн аудитаар 2,524.0 сая төгрөгийн 70 зөрчил илрүүлэн 354.7 сая төгрөгийн 55 төлбөрийн акт тавьснаас 301.0 сая төгрөг, 352.1 сая төгрөгийн 5 албан шаардлага өгснөөс 31.3 сая төгрөг барагдаж, 1,807.1 сая төгрөгийн 10 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2024 онд хийсэн аудитаар 5,200.9 сая төгрөгийн 57 зөрчил илрүүлэн 52.3 сая төгрөгийн 18 төлбөрийн акт, 492.9 сая төгрөгийн 26 албан шаардлага бичигдэж, 4,327.2 сая төгрөгийн 12 зөвлөмж өгч, 328.4 сая төгрөгийн 1 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлээд байна.

В.2. Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал зардал хэмнэгдсэн байна.

Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2023, 2024 оны аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвийн хэмнэлт гарсан байдлыг авч үзлээ.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага тодотгон батлагдсан төлөвлөгөөгөөр 121,177.9 сая төгрөг, гүйцэтгэлээр 100,839.3 сая төгрөгийг зарцуулж, 20,338.6 сая төгрөгөөр дутуу буюу гүйцэтгэл 83,2 хувь байна. Хөрөнгийн зардалд 14,895.3 сая төгрөг зарцуулагдаагүй, урсгал зардал 3,764.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Хүснэгт 3.Төв аймгийн 2023 оны нийт зарлагын эдийн засгийн ангилал

/сая төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны гүйцэтгэл	2023 оны				
		Анх батлагдсан	Тодотгосон төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,430.9	100,072.1	121,177.9	100,839.3	83.2	20,338.6
А. Урсгал зардал	37,860.1	47,540.6	54,020.7	50,256.6	93.0	3,764.1
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	11,014.9	15,898.4	17,101.6	16,725.0	97.8	376.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,377.1	1,987.3	2,141.2	2,064.5	96.4	76.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,654.9	17,152.7	17,897.3	17,011.6	95.1	885.7
Хангамж, бараа материалын зардал	1,013.2	1,206.4	1,262.5	1,234.3	97.8	28.2
Нормативт зардал	153.8	180.5	173.9	169.9	97.7	4.0
Эд хогшил, урсгал засварын зардал	583.8	415.0	565.0	541.1	95.8	23.9
Томилолт, зочны зардал	179.6	242.9	266.8	242.4	90.9	24.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,227.0	2,031.5	2,044.8	1,944.9	95.1	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	5,403.7	7,441.9	10,856.2	8,755.5	80.6	2,100.7
Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	321.8	224.4	883.1	883.1	100.0	-
ТАТААС	272.1	102.0	102.0	102.0	100.0	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	658.2	657.6	726.3	582.3	80.2	144.0
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,729.4	47,132.9	62,720.5	47,825.2	76.3	14,895.3
В. Эргэж төлөгдөх цэвэр зээл	1,841.4	5,398.6	4,436.7	2,757.5	62.2	1,679.2

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хөрөнгийн зардал буюу барилга, байгууламж, их засвар, тоног төхөөрөмж зэрэг хөрөнгө оруулалтын зардал нь гүйцэтгэлээр санхүүжсэн, үлдэгдэл санхүүжилт нь барьцаа санд байршсан, эргэж төлөгдөх цэвэр зээл буюу хоршоо хөгжүүлэх, мал хамгаалах зэрэг тусгай сангуудын эргэн төлөлттэй холбоотой дутуу гарсан зардал зэргийг хэмнэлтэд тооцоогүй.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах 62 байгууллагын хувьд 2023 онд 3,764.1 сая төгрөгөөр урсгал зардал хэмнэсэн байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага тодотгон батлагдсан төлөвлөгөөгөөр 159,896.4 сая төгрөг, гүйцэтгэлээр 125,712.3 сая төгрөгийг зарцуулж, 34,184.1 сая төгрөгөөр дутуу буюу төсвийн гүйцэтгэл 78,6 хувь байна. Дутуу зарцуулалтыг задалбал, урсгал зардал 10,645.7 сая төгрөгөөр хэмнэлттэй, хөрөнгийн зардалд 21,212.1 сая төгрөг зарцуулагдаагүй, эргэж төлөгдөх цэвэр зээл 1,486.0 сая төгрөгийн эх үүсвэр бүрдээгүй, мөн 840.4 сая төгрөгийг зарцуулаагүй байна.

Хүснэгт 4. Төв аймгийн 2024 оны нийт зарлагын эдийн засгийн ангилал

/сая төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны гүйцэтгэл	2024 оны				
		Анх батлагдсан	Тодотгосон төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	100,839.3	139,544.5	159,896.4	125,712.3	78.6	34,184.1
А. Урсгал зардал	50,256.6	70,172.1	82,485.6	71,839.8	87.1	10,645.7
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	16,725.0	25,544.6	25,510.3	24,284.5	95.2	1,225.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,064.5	3,234.9	3,196.0	2,996.9	93.8	199.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,011.6	21,373.2	22,122.2	20,555.3	92.9	1,566.9
Хангамж, бараа материалын зардал	1,234.3	1,415.2	1,500.8	1,409.1	93.9	91.7
Нормативт зардал	169.9	265.5	276.5	273.9	99.0	2.6
Эд хогшил, урсгал засварын зардал	541.1	1,345.8	2,397.3	2,278.4	95.0	118.9
Томилолт, зочны зардал	242.4	383.7	465.3	421.7	90.6	43.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,944.9	2,921.4	3,449.8	3,334.5	96.7	115.3
Бараа үйлчилгээний бусад зардал	8,755.5	12,648.8	22,189.0	15,036.9	67.8	7,152.1
Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	883.1	20.5	125.7	125.7	100.0	0.0
ТАТААС	102.0	198.2	198.2	198.2	100.0	(0.0)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	582.3	820.3	1,054.5	924.7	87.7	129.8
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,825.2	65,610.1	73,659.6	52,447.5	71.2	21,212.1
В. Эргэж төлөгдөх цэвэр зээл	2,757.5	3,762.3	3,751.3	1,424.9	38.0	2,326.4

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2024 онд цалин, шимтгэлийн зардал 1,424.8 сая төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 1,566.9 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 91.6 сая төгрөг, нормативд зардал 2.6 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 118.9 сая төгрөг, дотоод албан томилолтын зардал 43.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардал 115.3 сая төгрөг, бараа ажил үйлчилгээний зардал 7,152.1 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Хөрөнгийн зардал 21,212.1 сая төгрөгөөр хэмнэсэн нь сумдын төсвийн шилжих үлдэгдэл болон орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хийгдэж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөхдөө хэт жижиглэн олон төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, төлөвлөсөн ажлуудын санхүүжилт дутуу, гүйцэтгэгч сонгон шалгаруулах явц удааширдаг, төсвийн тодотголыг ойрхон хийж байгаагаас цаг хугацааны хувьд он дамжиж байгаа зэргээс шалтгаалж дутуу зарцуулагдсан байна. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэр дутуу бүрдсэн, зарим сумдад зээлийн сонгон шалгаруулалтад тэнцсэн төсөл арга хэмжээ ирээгүйгээс 2,326.3 сая төгрөгөөр төсвийн зарлага хэмнэхэд нөлөөлсөн байна.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал зардал 3,764.1 сая төгрөг, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал зардал 10,645.7 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

В.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил буурахгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” гэж заасан.

Төв аймаг дахь Төрийн аудитын газар шилэн дансны хуулийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан нийцлийн аудит хийхэд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг хугацаа хоцроосон, мэдээллийг байршуулаагүй, дутуу мэдээлсэн зэрэг зөрчил илрүүлж, нийт 114 байгууллагад 8,940.5 сая төгрөгийн 79 зөвлөмж, 4,869.2 сая төгрөгийн 35 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Төсвийн шууд захирагчдын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг хугацаа хоцроосон, мэдээллийг байршуулаагүй, дутуу мэдээлсэн зэрэг зөрчил илрүүлж, нийт 5,448.3 сая төгрөгийн 19 албан шаардлага, 28,709.9 сая төгрөгийн 99 зөвлөмж, 4 байгууллагын 6 албан тушаалтанд хариуцлага тооцох 6,024.6 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Хүснэгт 5. 2022-2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчил

Аудитын шийдвэрлэлт	2022 оны Санхүүгийн тайлангийн аудитаар		2023 оны Санхүүгийн тайлангийн аудитаар		2024 оны Санхүүгийн тайлангийн аудитаар	
	тоо	Дүн / сая төгрөгөөр/	тоо	Дүн / сая төгрөгөөр/	тоо	Дүн / сая төгрөгөөр/
Зөвлөмж	170	25,828.0	79	8,940.5	99	28,709.9
Албан шаардлага	58	15,017.9	35	4,869.2	19	5,448.3
Хариуцлага тооцуулах	7	0	0	0	4	6,024.6
Нийт зөрчил	235	40,845.9	114	13,809.7	122	40,182.8

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Төсвийн шууд захирагчдын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийг цахим системд мэдээлэл оруулсан байдлаар авч үзвэл.

- Шилэн дансны цахим системд 122 байгууллага 611.2 сая төгрөгийн нийт 710 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.
- Шилэн дансны цахим системд 122 байгууллага 10,058.9 сая төгрөгийн 24 мэдээллийг дутуу мэдээлсэн.
- Шилэн дансны цахим системд 94 байгууллага 29,512.6 сая төгрөгийн 396 мэдээллийг мэдээлээгүй байна.

Орон нутагт Төрийн аудитын байгууллага болон Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Төрийн байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх болон тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцас, цалин хөлс, зөвлөхтэй холбоотой Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хориглолт зөрчигдөж байна.

2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэмнэлтийн бусад арга хэмжээ гэсэн 15 дугаар зүйлтэй холбоотой зөрчлүүд нь 2023 оноос буурсан байна.

3. Монгол Улсын ЗГХЭГ-ын даргын төсвийн багцаас 2 сумын 7 багийн төвийн байр засварласан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "...дараах зүйлсийг тусгахыг хориглоно", 13.4.4-д "багийн төв, хорооны засаг захиргааны зориулалттай барилга барих, тохижуулах, засварлах, ..." гэж заасныг зөрчсөн байна.

4. Төв аймгийн хувьд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг 100 хувь цахимаар зарлаж байна.

5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд орон нутагт Төрийн аудитын байгууллага хяналт хэрэгжүүлж байна.

6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн сүүлийн хоёр жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал зардал хэмнэгдэж байгаа нь Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой байна.

7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил буурахгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Төв чандмань ДЭХГ ОНӨААТҮГ-ын Захирал Д.Баярбатад:

Төв чандмань ДЭХГ ОНӨААТҮГ-ын захирлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилж, цалин хөлсийг тогтоосон, гүйцэтгэх захирлын тушаалаар жил бүр тухайн онд мөрдөх орон тоо цалингийн санг баталсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасныг зөрчиж байгаа тул хуульд нийцүүлэн байгууллагын цалин хөлсний нийтлэг жишгийг аймгийн ИТХ-аар батлуулан мөрдөж ажиллах

Аймгийн БЗОСК ОНӨААТҮГ-ын Захирал Ц.Дашдэмбэрэлд:

БЗОСК ОНӨААТҮГ-ын ТУЗ-ын тогтоолоор захирал, албан хаагчдын цалин хөлс, цалингийн санг баталсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасныг зөрчиж байгаа тул хуульд нийцүүлэн байгууллагын цалин хөлсний нийтлэг жишгийг аймгийн ИТХ-аар батлуулан мөрдөж ажиллах


ҮАГ-аар уламжилж ЗГХЭГ-т:

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх жагсаалтад тусгахыг хориглосон төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхгүй байх

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор		Ц.Хишигжаргал
Аудитын менежер		О.Амаржаргал

Тайлан бичсэн:

Ахлах аудитор		Л.Жаргалсайхан
Аудитор		Г.Ариун-Уянга



Холбогдох байгууллагын санал:



**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**

41111 Төв аймаг, Зуунмод сум, Номг 1 дүгээр баг
Утас: 70273623, И-мэйл: tuv_xdtg@tov.gov.mn

2025.04.23 № *02/718*

танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
үр дүн нийцлийн аудитын тайлантай танилцлаа.

Уг тайлантай холбоотой санал, дүгнэлт
байхгүй болно.

ДАРГА  С.ЦОГБАЯР



4125020901



ТӨВ АЙМГИЙН
ТӨВ ЧАНДМАНЬ-ДЭХГ ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ, АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

41100 Төв аймаг, Зуунмод сум, Номт баг
Утас/факс: 70273756

2025.04.25 № 92,
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН АУДИТИЙН ГАЗАРТ

Манай байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж шалгасан тайлан, зөвлөмжтэй танилцлаа. Тайлантай холбоотой санал хүсэлт байхгүй болно.

ЗАХИРАЛ

Д.БАЯРБАТ

D:/Ajil2005-2025/toot



**ТӨВ АЙМАГ
БАРИЛГА ЗАХИЛАГЧ, ОРОН
СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНГААГУУ**

41015, Төв аймаг, Буянт-Уул сум
Утас: 70272840

2025.04.25 № 44
Тайлбар: _____

**ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Төв аймаг дахь төрийн аудитын газраас хийгдсэн "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" хуулийн хүрээнд хийгдсэн нийцлийн аудитын тайлантай танилцсан болно.
Холбогдох санал байхгүй болно.



ЗАХИРАЛ *Ц. Дашдэмбэрэл* Ц. ДАШДЭМБЭРЭЛ

4125050111



Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төр захиргааны 2-р байр
Утас: +976 70272582, +976 70273465
И-мэйл: tuv@audit.gov.mn Веб сайт: www.audit.mn